

5

МАНАЙ УЛСАД БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

Д.Чүлтэм

Бэлчээр бол эдийн засгийн хямд өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх капитал юм

Манай улсын хөдөө аж ахуйн газрын 90 гаруй хувийг бэлчээрийн газар эзэлдэг. Бэлчээрийн эдэлбэр газар гэдэг ойлголт нь юуны урьд аж ахуйн зорилго ач холбогдлын хувьд бэлчээрт ашиглах боломжтой, малд тэжээл болох ургамал ургаж, ус, өвс тэжээлээр мал аж ахуйн хэрэгцээ шаардлагыг хангаж чадах нөхцөл бүхий газрын тухай ойлголт юм.

Бэлчээрийн эдэлбэр газар нь малын тэжээлийн үндсэн эх сурвалж болохын зэрэгцээ малаар дамжин ашиглагддаг учир мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүхий л үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Манай улсын “Газрын тухай” хуульд² “Бэлчээр” гэж мал амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газрыг ойлгодог гэж томъёолжээ. Бэлчээр нь нутаг орон зай төдийгүй малын тэжээлийн хэрэгцээг тэнцвэржүүлэхэд чухал нөлөө бүхий хөдөө аж ахуйн газар юм. 2008 оны байдлаар манай улсын хөдөө аж ахуйн нэг га газарт дунджаар 13890 төгрөгний, үүнээс мал аж ахуйн 11940 төгрөгний бүтээгдэхүүн үйлвэрлэсэн байна. Бэлчээр буюу бэлчээрийн эдэлбэр газар бол манай улс орны хамгийн үнэт баялаг бөгөөд хамгийн хямд бүтээгдэхүүн өгч байгаа үйлдвэрлэлийн чухал хэрэгсэл, эдийн засгийн хямд өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх өгөөж бүхий капитал билээ.

² “Газрын тухай” Монгол улсын хууль Зуунымэдээ 2002.08.01.№186

2.Бэлчээр бол малын бэлчээр төдийгүй хүмүүсийн амьдрах газар нутгийг хамтатган багтаадаг

Манай эрдэмтдийн судалгаанаас үзвэл,бэлчээр бол мал,хүн амьдрах үйлдвэрлэлийн нөхцөл болдог ажээ.Доктор,профессор Д.Базаргүр “Байгалийн геоэкологийн нөхцөлд бэлчээрийн малын биоэкологийг малчдын ухамсарт хөдөлмөр болох нүүдлийн аргаар зохицуулан эрхэлж,нөхөн үйлдвэрлэл явуулж байгаа газар зүйн хил хязгаар бүхий цогцолбор шинжийг агуулсан жилийн дөрвөн улирлын нутгийг бэлчээрийн малын **экологийн зохистой нутаг** гэнэ. Бэлчээрийн малын экологийн зохистой нөхцөл нь бодитой оршиж нүүдэлч малчдын амьдрах хүрээ,орон байр,матариаллаг үйлдвэрлэлийн нөхцөл болдгийн хувьд байгалийн нөхцөл,нөөцийг цаг хугацааны эргэлттэй холбоотойгоор орон зайгаар зохицуулагдсан таатай нөхцөл буюу “экологийн цагираг”-ийг үүсгэнэ³ гэжээ.

Доктор, профессор Н.Эрдэнэцогт “Нутаг бэлчээр гэдэг ойлголтод зөвхөн малын бэлчээр төдийгүй хүмүүс, малчдын амьдрах газар нутгийг хамтатган багтаадаг. Нутаг бэлчээр гэдэг нь өрх,хот айлын аж ахуй эрхлэх хүмүүс,гэдгээрийн адуулан маллаж буй мал сүргийн амьдралын хэвийн нөхцлийг хангах тухайн орон нутгийн экологийн тодорхой нөхцөл юм.⁴ гэснээс үзвэл бэлчээрийн тухай ойлголт нь мал төдийгүй хүний амьдрах орчныг ч хамааруулан үзэж болох талтай.

Дэлхийн нийт бэлчээрийн 1/3хувь нь нүүдлийн мал аж ахуйн бүс нутагт байршдаг байна.”Дэлхийн газрын фондын ...1997 оны байдлаар ... 97,4 хувийг хуурай газар,10,3 хувийг түр зуурын ашиглалттай тариалангийн газар,0,9 хувийг тариалангийн газар, 25,5 хувийг бэлчээр, 31,2 хувийг ой, 29,9 хувийг бусад эдэлбэр газар эзэлж байна. БНХАУ,Энэтхэгийн энэхүү бэлчээрийн талбайг оролцуулбал дэлхийн нүүдэл,заримдаг нүүдлийн мал аж ахуй бүхий районд дэлхийн нийт бэлчээрийн талбайн 33,5 хувь буюу 1126,0 сая га бэлчээр байгааг нэлээд баттай хэлж болно”⁵ “Бэлчээр болон ажиллах хүчний харьцангуй их оронд мал өсгөх боломж их байна”(3,50)⁶ гэж доктор,профессор Б.Мягмаржав бичжээ.

Дээр дурьдсанаас үндэслэн бэлчээр нь малын төдийгүй хүний амьдрах орчин,хүн хүч нь малыг өсгөх боломжийг улам ихэсдэг гэж үзэж болох байна.

³ Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй Дамбын Базаргүр Улаанбаатар 2005

⁴ Монголын нүүдлийн мал аж ахуй. Н.Эрдэнэцогт Улаанбаатар 1998

⁵ Дэлхийн нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн асуудлууд Б.Мягмаржав. Улаанбаатар 2004


⁶ Азийн нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн үндсэн асуудал Б.Мягмаржав Улаанбаатар 2007

3. Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргуудаархи нутаг дэвсгэр, хүн ,малын байршил

“Газрын төлбөрийн тухай” хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 152-р тогтоолын дагуу манай нийт нутаг дэвсгэрийг:

- 1.Хангай,хэнтийн уулархаг нутаг(ху)
- 2.Алтайн уулархаг нутаг(ау)
- 3.Говийн уулархаг,талархаг нутаг(гт)
- 4.Тал нутаг(т) гэж 4 томоохон тойрогт хуваасан юм. Эдгээр тойргуудаархи нутаг дэвсгэрийн хувийн жин,хүн ,малын байдлыг авч үзье.

Улсын дунджаар тооцон үзвэл нэг хавтгай дөрвөлжин километр газарт 1.69 хүн оногдож байгаа юм. Үүнээс Хангай, Хэнтийн уулархаг нутагт 3.81, Алтайн уулархаг нутагт 0.85, говийн уулархаг, талархаг нутагт 0.63, тал нутагт 0.76 хүн ногдож байгаа бөгөөд, Хангайн Хэнтийн уулархаг нутгаас Улаанбаатарын нутаг дэвсгэр хүн амыг тусад нь тооцвол дээрхи 3.81 хүн 1.68 болж багассан байна. Үүнийг диаграммаар дүрслэвэл:



Хангай, Хэнтийн уулархаг нутагт нийт газар нутгийн 31.7 хувийг эзэлж хүн амын 71.6 хувь, мал сүргийн хувьд тэмээний 5.5 %, адууны 54.8%, үхрийн 69.3, хонины 53.5, ямааны 41.7 хувь, Алтайн уулархаг нутаг газар

нутгийн 12.8 хувийг эзэлж, хүн амын 6.4 хувь, мал сүргийн хувьд 28.5, 7.0, 5.9, 8.6, 14 хувь. Говийн уулархаг, талархаг нутаг, газар нутгийн 39.1 хувь, хүн амын 14.6 хувь, мал сүргийн хувьд 58.1, 20.6, 14.0, 23.8, 33.9, Тал нутаг, газар нутгийн 16.4 хувь, хүн амын 7.4 хувь, мал сүргийн хувьд 7.9, 17.6, 10.8, 14.1, 10.4 хувьд тус тус байршиж байна.

Эндээс үзэхэд газрын үржил сайтай Хангай, Хэнтийн уулархаг нутаг манай улсын нийт нутаг дэвсгэрийн 1/3 орчмыг эзэлж, энэ хүн амын 70 гаруй хувь нь суурьшиж, мал сүргээс адуу, үхэр, хонины 53.5-69.3 хувь нь байршдаг ажээ.

2. Хүн амын нягтрал ба нутаг дэвсгэрийн нэгжид хоогдох малын тооны нөлөөллийн эконометрик болон олон хэмжээст статистик шинжилгээ шинжилгээ.

Эконометрикийн шинжилгээг Монгол Улсын газрын нэгдмэл сангийн тойргуудаар ангилагдсан нийт сумаар болон тойрог тус бүрээр хүн амын нягтралд нутаг дэвсгэрийн нэгжид ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тооны нөлөөлөлийг SPSS хэрэглээний программ ашиглан регрессийн шинжилгээгээр үнэлэх зорилт тавилаа. Энэхүү хамаарлын судалгаа хийхэд ажиглалтын мэдээллийн статистикийн нэг төрөл байдлыг хадгалах үүднээс нийт мэдээлэлд бусдаас онцгойрсон аймгийн төвд хамаарах сум болон зарим онцгойрсон сумуудыг оролцуулахгүйгээр хийлээ. Үүнд улсын хэмжээнд 313 сумыг хамруулсан судалгааны үр дүнгээр регрессийн шинжилгээ хийхэд

Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
	B	Std. Error	Beta		
1 (Constant)	-,0.35	,003		-13,178	,000
n_mal	,0.83	,003	,867	30,749	,000

гэж тодорхойлогдож байгаагаас үзвэл регрессийн тэгшитгэл нь:
 $Y_i^n = -0.035 + 0.003 X_i$ Y_i^n - хүн амын нягтрал X_i –малын тоо
 T (-13.178) (30.749)

болж нутаг дэвсгэрийн нэгжид ногдох малын тоо нь $\alpha=0.05$ ач холбогдлын түвшин 95 хувийн үнэний магадлалтайгаар хүн амын нягтрал малын тоо хоорондоо хамааралтай байна. Үүнээс гадна бидний тодорхойлсон регрессийн тэгшитгэлийн тайлбарлагч нутаг дэвсгэрийн нэгжид ногдох малын тоо нь хүн амын нягтралд ямарч нөлөөгүй гэсэн $H_0: \beta_2 = 0$ таамаглалыг дисперсийн шинжилгээгээр шалгахад F- тархалт нь $F=945,499$ гэж тодорхойлогдсон байна.

Model	Sum of Squares	df	Mean Square	F	Sig
1 Regression	1.269	1	1.269	945,499	,000 ^a
Residual	,419	312	,001		
Total	,1.688	313			

$\alpha=0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн магадлалтайгаар $H_0: \beta_2 = 0$ гэсэн анхны дэвшүүлсэн тэг таамаглалыг няцааж түүний өрсөлдөгч $H_1: \beta_2 \neq 0$ гэсэн нутаг дэвсгэрийн нэгжид ногдох малын тоо нь хүн амын нягтралд нөлөөтэй гэсэн өрсөлдөгч таамаглалыг хүлээн авах үр дүнд хүрлээ. Иймд бидний сонгосон

хувьсагчид нь зохистой болжээ гэж дүгнэж байна. Судалгааны үр дүнгээр детерминацийн коэффициент нь 0.852 гэж тодорхойлогдсон нь бидний сонгосон тайлбарлагч хүчин зүйлийн хувсагч нь 85.2 хувиар хүн амын нягтралыг тайлбарлах боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Ийнхүү бүх тойргийг хамарсан нийт сумын мэдээлэлд эконометрикийн шинжилгээ хийхийн зэрэгцээ тойрог тус бүрээр эконометрикийн шинжилгээ хийлээ.

1. Хангай, Хэнтийн уулархаг нутгийн 142 сумыг судалгаанд хамруулж, ажиглалт хийсэн мэдээллийг ашиглан регрессийн шинжилгээг хийхэд

Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
	B	Std. Error	Beta		
1 (Constant)	-.004	.004		-1,119	,265
n_mal	.025	.004	,452	6,038	,000

гэж тодорхойлноос үзвэл регрессийн тэгшитгэл нь

$$Y_i^n = -0.004 + 0.025 X_i$$

$$T \quad (-1.119) \quad (6.038)$$

Болж тайлбарлагч хувьсагч нь $\alpha= 0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн үнэний магадлалтайгаар хүн амын нягтрал, малын тоо хоорондоо хамааралтай байна. Үүний зэрэгцээ $H_0 : \beta_2 = 0$ буюу тайлбарлагч хувьсагчийн нөлөөгүй гэсэн таамаглалыг дисперсийн шинжилгээгээр үнэлж

Model	Sum of Squares	df	Mean Square	F	Sig
1	.018	1	.018	36.454	
Regression	.069	142	.000		,000 ^a
Residual	.087	143			
Total					

$F= 36.454$ гэсэн тодорхойлогчдын $\alpha= 0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн магадлалтайгаар $H_0 : \beta_2 = 0$ тэг тэгшитгэлийг няцааж $H_1 : \beta_2 \neq 0$ өрсөлдөгч таамаглалыг хүлээн авч хувьсагчдын сонголт нийцтэй байна. Детерминацийн коэффициент 0.652 буюу 65 хувиар тайлбарлагчдын байгаа хувьсагчийг хүчин зүйлийн хувьсагчийн сонголт зохистой байна гэдгийг илтгэж байна.

2. Алтайн уулархаг нутгийн 36 сумыг сонгосон мэдээнд түшиглэн
эконометрикийн шижилгээний үр дүнгээр

Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
	B	Std. Error	Beta		
1 (Constant)	-.052	.009		-5,119	,000
n_mal	,162	,017	,846	9,388	,000

$$Y_i^n = -0.052 + 0.162 X_i$$

T (-5.928) (9.388) гэж тодорхойлогдож, тайлбарлагч хувьсагч нь $\alpha = 0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн үнэний магадлалтайгаар хүн амын нягтрал, малын тоо хоорондоо хамааралтай байна. /дисперсийн шинжилгээгээр /

Model	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1 Regression	.075	1	.075	88.140	
Residual	.030	35	.001		,000 ^a
Total	.105	36			

F= 88.140 гэж тодорхойлогдож $\alpha = 0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн агадлалтайгаар $H_0: \beta_2 = 0$ гэсэн тэг тэгшитгэл няцаагдаж $H_1: \beta_2 \neq 0$ таамаглалыг хүлээн авч регрессийн тэгшитгэл нь хандлага тодорхойлох боломжтойг илтгэж байна. Детерминацийн коэффициент нь 0.798 гэж тодорхойлогдож 79.3 хувиар хүн амын нягтралыг тайлбарлах боломжтой байна.

3. Говийн уулархаг талархаг нутгийн 91 сумын мэдээг ашиглан
эконометрикийн шижилгээ нь

Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
	B	Std. Error	Beta		
1 (Constant)	-.001	.001		,935	,352
n_mal	,013	,001	,725	9,982	,000

гэж тодорхойлогдож регрессийн тэгшитгэл

$$Y_i^n = -0.001 + 0.13 X_i$$

T (0.935) (9.982) болж тайлбарлагч хувьсагчийн регрессийн коэффициент нь $\alpha = 0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн үнэний магадлалтайгаар хүн амын нягтрал, малын тоо хамааралтай байна. Дисперсийн шижилгээ нь

Model	Sum of Squares	df	Mean Square	F	Sig
1 Regression	.003	1	.003	99.632	,000 ^a
Residual	.003	90	.000		
Total	.007	91			

гэж тодорхойлогдож $F=99.632$ байсан нь $H_0: \beta_2 = 0$ таамаглалыг няцааж $H_1: \beta_2 \neq 0$ таамаглалыг хүлээн авч $\alpha=0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн үнэний магадлалтайгаар регрессийн тэгшитгэлийн нийцтэйг илтгэж байна.

Детерминацийн коэффициент 0.725 буюу тайлбарлагч хувьсагч нь 72.5 хувиар тайлбарлаж байна.

4. Тал нутгийн 40 сумын мэдээнд түшиглэн эконометрикийн шинжилгээ

Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
	B	Std. Error	Beta		
1 (Constant)	,001	,001		1.935	,198
n_mal	,011	,002	,619	4.982	,000

$$Y_i^n = -0.001 + 0.011 X_i$$

T (1.308) (4.919)

$\alpha=0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн үнэний магадлалтайгаар хүн амын нягтрал, малын тоо хамааралтай байна. Детерминацийн коэффициент 0.619 буюу хүн амын нягтралыг 61.9 хувиар тайлбарлаж байна. Регрессийн тэгшитгэлийн нийцтэй байдлыг дисперсийн шинжилгээний үр дүн


Model	Sum of Squares	df	Mean Square	F	Sig
1 Regression	.000	1	.000	24.193	,000 ^a
Residual	.000	39	.000		
Total	.001	40			

$F=24.193$ гэж тодорхойлогдож $\alpha=0.05$ ач холбогдлын түвшинд 95 хувийн магадлалтайгаар регрессийн коэффициентийн нийцтэйг илтгэж байна. Детерминацийн коэффициент 0.619 буюу 61.9 хувиар тайлбарлаж байна. Ийнхүү эконометрикийн шинжилгээний үр дүнг харьцуулан үзвэл тойрог бүрийн тоон мэдээлэл түүний бүрэлдэхүүн хэсгийг агуулж байгаа сумуудаас шалтаалан тайлбарлах хэмжээ нь янз бүрээр тодорхойлогдож байна. Харин тойргуудын хэмжээнд болон тойрог бүрд $H_0: \beta_2 = 0$ буюу хүн амын нягтралд нутаг дэвсгэрийн нэгжид ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо нөлөөлөөгүй гэсэн таамаглалыг шалгахад $H_1: \beta_2 \neq 0$ таамаглалыг бүгдээрээ 95 хувийн магадлалтайгаар

регрессийн шинжилгээнд сонгосон үзүүлэлтүүдийн нийцтэй байдлыг илтгэж эдгээр үр дүнгээр ирээдүйн хандлага тодорхойлох үндэслэлтэй байна. t статистик таамаглал шалгахад судлагдагч тайлбарлагч нутаг дэвсгэрийн нэгжид ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тооны нөлөөллийг илтгэх коэффициентийн нийцтэй байдлыг шалгахад 95 хувийн магадлалтайгаар нийцтэй төлөв ажиглагдаж байна.

Өмнөх шинжилгээг үргэлжлүүлэн газрын нэгдмэл сангийн тойргуудаар дээрхи үзүүлэлтийн байдалд олон хэмжээст статистик шинжилгээний нэг цөм кластерийн шинжилгээ хийж үзье. Үүний тулд тойрог бүрээр Дендерграмм байгуулж, га газарт ногдох хүн ам, мал сүргийн нягтралаас хамааран үүсэх график дүрслэл, түүнийг нарийвчлан тайлбарля.

1. Хангай, Хэнтийн уулархаг нутаг



Энэ бүс нутагт хамаарах 12 аймгийн нийт 142 сум судалгаанд хамрагдлаа.


- Үүнд: 1. Архангай аймаг 18 сум
- 2. Булган аймаг 15 сум
- 3. Төв аймаг 22 сум
- 4. Хөвсгөл аймаг 22 сум
- 5. Сэлэнгэ аймаг 16 сум
- 6. Өвөрхангай аймаг 7 сум
- 7. Завхан аймаг 18 сум
- 8. Хэнтийн аймаг 10 сум
- 9. Дархан Уул аймаг 1 сум
- 10. Баянхонгор аймаг 7 сум
- 11. Увс аймаг 4 сум
- 12. Дорнод аймаг 2 сум

Эдгээр 1-23 хүртэл сумаас бүрдсэн 17 кластер. Үүнээс 10 мегокластер үүсгэгдлээ. Зарим аймгийн сумдыг дурьдвал 2 дахь мегокластерт дангаараа нэгтгэгдэж 3 дахь мегокластерийг үүсгэж байгаа Сэлэнгэ аймгийн Сайхан сум нэг(га газарт ногдох хүн 0.0632), 3 дахь

мегокластерт дангаараа нэгтгэгдэж 4 дэх мегокластерийг үүсгэж байгаа Сэлэнгэ аймгийн Мандал сум (нэг га газарт ногдох хүн 0.0488), 4 дэх мегокластерт дангаараа нэгтгэгдэж 5 дахь мегокластерийг үүсгэж байгаа Сэлэнгэ

аймгийн Шаамар сум (нэг га газарт ногдох хүн 0.0619, хонь 0.7983). 6 дахь мегокластерт дангаараа нэгтгэгдэж 7 дахь мегокластерийг үүсгэж байгаа Архангай аймгийн Эрдэнэмандал (нэг га газарт ногдох хүн 0.0174, хонь 1.3962) онцолж үзвэл: Улсын дундажаас нэг га газарт Сайхан сум хүнээр 3.74 дахин, хониор 2.2 дахин, Мандал сум хүнээр 2.89 дахин хониор 1.31 дахин, Шаамар сум хүнээр 3.66 дахин, хониор 1.89 дахин, Эрдэнэмандал сум хүнээр 1.03 дахин, хониор 3.32 дахин тус тус илүү байгаа нь ийм дүрслэл үүсгэхэд хүргэжээ. Энэ нутагт олон аймаг, сум хамаарч байгаагаас гадна 10 мегокластер үүсгэж байгаа нь газар нутгаа түшсэн хүн ам, малын нягтрал, тэдгээрээс үүсэх хамаарлаас үзвэл энэ нутагт цаашид нарийвчилсан бүсчлэл шаардлагатай гэдгийг судалгааны үр дүнд харуулж байна.

2. Алтайн уулархаг нутаг.



Энэ нутагт 7 аймгийн 36 сум судалгаанд хамрагдсан. Үүнд :

1. Өмнөговийн 9
2. Баянхонгорын 3
3. Говь-Алтайн 3
4. Өвөрхангайн 1
5. Баян-Өлгийн 12
6. Ховдын 4
7. Увсын 4 сум байна. Шинжилгээний үр дүнгээр дээр дурьдсан 7 аймгийн 36 сум 3 мегокластерт хуваагдаж байна. Эхний мегокластерт 9 сум. Үүнд:
 1. Өмнөговийн 8 сум
 2. Баянхонгорын 1 сум,
 3. 2 дахь мегокластерт 14 сум Үүнд:


1. Баян-Өлгийн 6
2. Говь-Алтайн 3
3. Баянхонгорын 2
4. Өвөрхангайн 1
5. Өмнөговийн 1
6. Увсын 1

3 дахь мегокластерт 13 сум Үүнд:

1. Баян-Өлгийн 6 сум
2. Ховдын 4 сум
3. Увсын 3 сум

Тус тус хамаарагдаж тухайн нутагт хүн амын болон нягтралаар томоохон бүлэглэл үүсгэж байна. Эндээс үзвэл энэ нутагт үзүүлэлт харьцангуй тогтвортой байна гэж үзэж болохоор байна.

3.Говийн уулархаг, талархаг нутаг




Энэ нутгийн 11 аймгийн 87 сум судалгаанд хамрагдлаа.

- Үүнд:
1. Баянхонгор аймгийн 9 сум
 2. Завхан аймгийн 5 сум
 3. Увс аймгийн 9 сум
 4. Говь-Алтай аймгийн 15 сум
 5. Дундговь аймгийн 8 сум
 6. Ховд аймгийн 12 сум
 7. Дорноговь аймгийн 13 сум
 8. Сүхбаатар аймгийн 3 сум
 9. Өвөрхангай аймгийн 5 сум
 10. Говьсүмбэр аймгийн 3 сум
 11. Өмнөговь аймгийн 5 сум

Кластерийн шинжилгээнээс үзэхэд эдгээр сумд нь хоёр томоохон бүлэгт хуваагдаж 5 мегокластер үүсгэн дээрх бүх сумыг хамаарч байгаагийн хувьд Хангай, Хэнтийн уулархаг нутгаас үзүүлэлтийн хувьд арай жигд байна гэж үзэж болох юм. Харин энд мегокластер 1-ийг үүсгэхэд

ганцаараа орж буй “М”кластерийн (Говьсүмбэр аймгийн Шивээговь сум) мегоккластер 4-ийг үүсгэхэд мөн ганцаараа орж буй Т кластер Дорноговь аймгийн Сайншанд сумыг онцгойлон авч үзэх шаардлагагүй гэж үзэж байна.

4. Тал нутаг



Энэ нутагт хамаарах 6 аймгийн 38 сумыг хамруулж кластерийн шинжилгээ хийв.

- Үүнд:
1. Дорнод аймгийн 11 сум
 2. Төв аймгийн 3 сум
 3. Дундговь аймгийн 7 сум
 4. Сүхбаатар аймгийн 9 сум
 5. Хэнтий аймгийн 7 сум
 6. Өвөрхангай аймгийн 1 сум

Кластерийн шинжилгээнээс хархад дээрх аймаг сумдаас 11 кластер, 3 мегоккластер үүсч байна. Энэ нутгийн шинжилгээнд Төв аймгийн Баян сум (нэг га газарт 0.0071 хүн, 0.3427 хонь) дангаараа, Хэнтий аймгийн Мөрөн сум (нэг га газарт 0.0088 хүн, 0.7764 хонь) дангаараа тус тус кластер үүсгэж байна. Энэ нь бүсийн дундажаас Баян сум нэг га газарт ногдох хүнээр 6.4 хувиар бага, хониор 2.0 хувиар илүү, харин Мөрөн сум нэг га газарт ногдох хүнээр 16.8 хувиар илүү, хониор 2.31 дахин илүү байгаа нь ийм дүрслэл үүсгэжээ. Энэ бүс нутагт цөөн сум хамрагдаж байгаа бөгөөд харьцангуй жигд үзүүлэлттэй цаашид энэ нутагт нарийвчилсан бүсчлэл шаардалагагүй боловуу гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ:

1. Дээр дурьдсан статистик шинжилгээгээр манай улсын газрын үнэлгээний тойргуудаархи нэг га газарт ногдох хүн амын нягтрал нь тухайн газарт ногдох малын нягтралаас хамааралтай болох нь

нотлогдож байна. Өөрөөр хэлбэл хүн ам нь малаа, мал нь газар нутаг бэлчээрээ дагадаг гэдгийг харуулж байна. Бэлчээр нь малын байгалийн идэш тэжээл, ус ундаа, нөмөр нөөлөг бүхий газар нутаг төдийгүй, хүн амын нутагшин амьдрах нөхцлийг бүрдүүлдэг ихээхэн онцлогтой юм.

2. Бэлчээрийн эдийн засгийн үнэлгээ нь зөвхөн мал бэлчээрлэх газар төдийгүй, хүн амын суурьшин амьдрах газрыг хамтад нь хамааруулдаг гэж үзэж байна.

3. Дээрх дөрвөн тойргоос Хангай, Хэнтийн уулархаг нутгийн тойрогт юуны өмнө нарийвчилсан үнэлгээ хийх нь зүйтэй гэсэн дүрслэл гарч байна.

5. Бэлчээрийг эзэнд нь ойртуулах тухайд

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20 гаруй хувийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн эзэлж байна. Үүний дийлэнх нь мал аж ахуйн бүтээгдэхүүн юм.

Мал аж ахуй дээр 16-аас дээш насны 360 гаруй мянган хүн, 170 гаруй мянган өрх байгаа бөгөөд 16 хүртлэх насны хүүхдийг оролцуулбал дээрх хүн амын тоо бараг 3 дахин нэмэгдэх бөгөөд эдгээр хүмүүс хуулийн дагуу тогтоосон хэмжээний газраа өмчилж авах эрхтэй.

Манай үндсэн хуулийн дагуу мал сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна. Одоо манай бүх мал хувийн өмчид байна. Харин бэлчээрийг иргэнд өмчлүүлж болохгүй. Бэлчээрийг өнөөдөр хэн эзэмшиж, ашиглаж байна гэвэл малчид уу? Төр үү? Эсвэл алин ч бишүү? Яагаад ингэж асуух болов гэвэл өнөөг хүртэл бэлчээрийн тухай хууль байхгүй, бэлчээрийн тухай хуулийн төсөл хоёр дахь удаагаа хийгдээд байгаа ч хууль болж гараагүй л байна. Малчдад бэлчээрийг эзэмшүүлээгүйгээс малчид үе удмаараа нутаглаж, өвөг дээдсийнхээ нэрээр нэрлэгдэх болсон өвөлжөө, худаг усандаа хоргодох, түүнийг додомдох, ойр хавьд нь бэлчээр сайжруулах ажил хийх ямар ч сонирхол байхгүй, малгүй л бол ажилгүй ч гэсэн хот орон бараадах болжээ. Бэлчээрийн газар бол малын үйлдвэрлэлийн бааз төдийгүй, хүмүүсийн амьдрах аятай нөхцөл, түүнчлэн амьжиргааны эх үүсвэр болох учиртай. Малчдад бэлчээрийн тодорхой хэсгийг 30 ба түүнээс дээш жилээр эзэмшүүлж, өвөлжөө, худаг усныхаа ойролцоо таримал бэлчээр бий болгож, түүнийгээ өөрсдөө ашиглахын зэрэгцээ бусдад түрээслүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай. Мөн байнга оршин суух тохилог орон сууц барих, сэргээгдэх эрчим хүчний байнгын эх үүсвэр ашиглах, био түлшээр ахуйн хэрэгцээгээ хангах, орон байраа дулаацуулах, сансрын холбоог ашиглан улс орон төдийгүй дэлхийн аль ч оронтой харилцах боломж нээлттэй болж байна. Малгүй ч өвөлжөө, худаг усаа тохижуулсан, сайжруулсан бэлчээртэй хүн сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ эзэмшсэн бэлчээрээ хөдөө аж ахуйн бус зориулалтаар (ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх, авто замд эзлэгдэх г.м.) ашиглуулсан тохиолдолд харьцангуй өндөр төлбөр тогтоож, түүний тодорхой хэсгийг өвс тэжээл бэлтгэх, бэлчээрийн талбайг сэргээх, малчдыг малжуулах зэрэгт хөрөнгийн эх үүсвэр болгон ашиглах боломжтой. Энэ бүхэнд бэлчээрийн төлбөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй, зах зээлийн мэдрэмжтэй тогтоож, мөрдүүлэх нь чухал болж байна.